



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/612

Булган сум

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны мн/124 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2024 оны мн/204 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг Орхон, Бүрэгхангай, Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр сумдыг 2024 оны 10 дугаар сарын 02-ноос 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд эмнэлгийн урьдчилсан үзлэг хийж, 10 дугаар сарын 13-16-ны өдөр Булган суманд төвлөрүүлэн зохион байгуулсугай.

2.Цэрэг татлагын товчоог 1 дүгээр, эмч нарын комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар, цэрэг татлагын эрүүл мэндийн урьдчилсан үзлэг явуулах хуваарийг 3 дугаар, зарцуулах хөрөнгийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталж, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг хуваарийн дагуу явуулах, цэрэг татлагын ажлыг сайтар зохион байгуулахыг Цэрэг татлагын товчоо (Д.Алтаншагай), Цэргийн штаб (Хурандаа Ч.Энхбаяр), эмч нарын комисс (Д.Зоригтбаатар)-т тус тус хариуцуулсугай.

3.2024 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагад зарцуулах 12,825,000 (арван хоёр сая найман зуун хорин таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.


4.Сумын Эрүүл мэндийн төв, Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж мансууруулах бодисын хамааралтай, энэ төрлийн эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн түүхий эдийг хэрэглэдэг, мансуурах донтой иргэдийн судалгаа, цэрэг татлагаас өмнө сүрьеэгийн сорил тавих ажлыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран өвчилж болзошгүй болон сүрьеэгийн ойрын хавьталтай цэргийн насны залуучуудын судалгааг тус тус гаргаж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Эмнэлгийн үзлэгт орох залуучуудын шинжилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 1, 6, 7 дугаар зүйлийг үндэслэн зохион байгуулахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга (П.Оюунцэцэг), Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга (Б.Ариунболд) нарт тус тус хариуцуулсугай.

6.Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллах, хугацаат цэргийн албанд татагдаж буй иргэнийг тээвэрлэх арга хэмжээг зохион байгуулахдаа хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөж, авто техникийн бүрэн бүтэн байдлыг сайтар хангах, хамрагдвал зохих хүмүүсийг бүрэн хамруулан аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хяналтын тоог биелүүлж, цэрэг татлагын ажлыг хугацаанд нь зохион байгуулж, дүнг 2024 оны 10 дугаар сарын 30-ны дотор илтгэхийг Цэрэг татлагын товчоо (Д.Алтаншагай), Цэргийн штаб (Хурандаа Ч.Энхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 09-ны/ний өдрийн А/612 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

2024 ОНЫ ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧОО

Цэрэг татлагын товчооны
дарга

Д.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
дарга)

Цэрэг татлагын товчооны
орлогч дарга

Ч.Энхбаяр (Цэргийн штабын дарга, Хурандаа)

Цэрэг татлагын товчооны
нарийн бичгийн дарга

Н.Төмөр-Очир (Цэргийн штабын тоо бүртгэлийн
офицер, Дэд хурандаа)

Цэрэг татлагын товчооны
Гишүүд:

Г.Ганбаяр (Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн
Дэд хурандаа)

Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга,
Дэд Хурандаа)

П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)

Д.Зоригтбаатар (Нэгдсэн эмнэлгийн захирал)

Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)

Н.Амартүвшин (Орхон сумын Засаг дарга)

М.Бадам (Бүрэгхангай сумын Засаг дарга)

Х.Энхбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийтлэг үйлчилгээний албаны дарга)


Б.Ариунболд (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн
дарга)

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)

Б.Намнансүрэн (Цэргийн штабын Орон нутгийн
хамгаалалт, сургалтын офицер, Хошууч)

Ц.Цэрэнтогтох (Цэргийн штабын дайчилгааны
офицер, Хошууч)

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 09-ны/ний өдрийн А/62 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



Эмч нарын комиссын бүрэлдэхүүн

- | | |
|--------------------------------------|----------------------------------------------------------------|
| 1. Ерөнхий эмч | М.Мягмар (Нэгдсэн эмнэлгийн
эмчилгээ эрхэлсэн орлогч дарга) |
| 2. Дотрын эмч | Б.Энхмөнх |
| 3. Мэс засал, Чих, хамар хоолойн эмч | М.Билгүүн |
| 4. Мэдрэл, сэтгэцийн эмч | Н.Уянгаа |
| 5. Нүдний эмч | М.Давхарбаяр (Амбулаторийн эрхлэгч) |
| 6. Арьс өнгөний эмч | Ч.Амаржаргал |
| 7. Сүрьеэгийн эмч | Г.Цэрэнлхам |
| 8. Шүдний эмч | Б.Бат-Ундраа |
| 9. Дүрс оношлогооны эмч | Б.Бүрэндондов |
| 10. Рентген техникч | Ж.Түвшинсанаа |
| Оношилгооны тасгийн лаборант | Д.Ганганцэцэг |

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 09-ны/ний өдрийн А/6.12... дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

СУМДАД ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГ
ЯВУУЛАХ ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Урьдчилсан үзлэг явуулах хугацаа	Үзлэгт орох хүний тоо	Цэргийн жинхэнэ албанд татах хүний тоо
1	2	3	4	5
1	Орхон	10-р сарын 02	130	17
2	Бүрэгхангай	10-р сарын 03	94	19
3	Баяннуур	10-р сарын 04	44	8
4	Дашинчилэн	10-р сарын 04	102	24
5	Рашаант	10-р сарын 05	109	28
6	Гурванбулаг	10-р сарын 06	102	22
7	Могод	10-р сарын 07	119	19
8	Хишиг-Өндөр	10-р сарын 08	110	24
9	Булган	10-р сарын 12	412	30
10	Аймгийн нэгдсэн үзлэг	10-р сарын 16		
Бүгд			1222	191

Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 09-ны/ний өдрийн А/612 дугаар
захирамжийн 4 дүгээр хавсралт

2024 ОНЫ ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГАД
ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ /төг/	Тайлбар
1	2	3	4
1	Цэрэг татлагын товчоо, сумаас цэрэг хүргэж ирсэн хүмүүс, Цэргийн ангиас цэрэг хүргэж ирсэн офицерууд, ЦТБ дээр ажиллах хүмүүсийг хооллох, байрлуулах	7875000	65 хүн 1 өдөрт 25000 төг 3 өдөр хооллоно. Байр-20*3*50000=3000000
2	Цэргийн албанд татагдсан залуучуудыг цэргийн анги байгууллагад хүргэх замд 1 удаа хооллоход	1000000	100 хүн 1 удаа (1 хүн 10000 төгрөгөөр хооллоно)
3	Суманд цэрэг татлагын урьдчилсан үзлэг явуулах, УБ хотруу цэрэг хүргэж өгөх унааны зардал /шатахуун/	1740000	Дизель түлш 500л*3480
4	Эмч нарын томилолтын зардалд	1260000	6 эмч 7 хоног*30000
5	Бусад зардалд	950000	Цэвэр ус, нойтон сальфетка, гар ариутгагч, маск гэх мэт
Бүгд			12,825,000